

2024 ОНЫ 07 ДУГААР САРЫН 22-НЫ ӨДРИЙН
ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨНД НИЙСЛЭЛ, ДҮҮРГИЙН УДИРДАХ
АЖИЛТНААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР

Үүргийн биелэлтийг Arial-12 фонтоор бичиж, **2024 оны 07 дугаар сарын 31-ний “Лхагва” гарагт** багтаан e-doc системээр албан бичгээр ирүүлж, ТЗУХ-ийн мэргэжилтэн (ERP Б.Одбаяр)-д файлаар ирүүлнэ үү. Хугацаа хэтэрсэн, албан бичгээр ирүүлээгүй тохиолдолд биелэлт ирүүлээгүйд тооцохыг анхаарна уу.

№	Өгсөн үүрэг даалгавар	Хариуцах эзэн
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БОЛОН ДҮҮРГИЙН МЕНЕЖЕРЭЭС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР		
2024-2025 ОНЫ ӨВӨЛЖИЛТИЙН БЭЛТГЭЛ ХАНГАХ АЖЛЫН ХҮРЭЭНД		
1	Өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын хүрээнд инженерийн шугам сүлжээ, авто зам, тохижилт, ногоон байгууламжийн ажлын нэгдсэн төлөвлөгөөг батлуулан, хэрэгжилтийг эрчимжүүлэх.	ТХҮХ, Инженерийн дэд бүтцийн байгуулагууд
2	Өвөлжилтийн үед хүндрэл гарч болзошгүй сургууль, цэцэрлэг, эмнэлэг, халаалтын зуух, бусад барилга байгууламжийн цахилгаан, дулаан, шугам сүлжээний засварын ажилд шаардагдах хөрөнгө оруулалтын тооцоо, судалгааг гарган, танилцуулах.	ЕБС, СӨББ, ЭМТ, Инженерийн дэд бүтцийн байгуулагууд
3	Орон сууцны барилгын хуучирч муудсан халаалтын дотор систем, гадна инженерийн шугам сүлжээний засвар, угаалга, шахалтыг гүйцэтгэж, худаг, камерын бүрэн бүтэн байдлыг шалган, сэргээн засварлаж, аюулгүй байдлыг тогтмол хангаж ажиллах.	ТХҮХ, Инженерийн дэд бүтцийн байгуулагууд
4	Газрын дуудлага худалдааг шуурхай зохион байгуулж, төсөвт орлого төвлөрүүлэх ажлаа эрчимжүүлж ажиллах.	ГЗБА
5	Нийслэлийн төсвийн өөрчлөлт хийх бэлтгэл ажлыг сайтар хангах.	СТСХ
6	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн төсөлд холбогдох саналыг хүргүүлэх.	ТЗУХ
ЦАГ ҮЕИЙН АСУУДЛУУДЫН ХҮРЭЭНД		
7	Монголын соёл, шашны зан үйл, уламжлалт хэв шинжийг хадгалсан, өвөрмөц онцлогтой “Даншиг наадам-Хүрээ цам” наадамд оролцох бэлтгэл ажлыг сайтар хангах.	НХХ
8	Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлын хүрээнд авто замын салбарт хийгдэж байгаа ажлуудыг эрчимжүүлж, байгууллагууд ажлын уялдаагаа, хангаж, тулгамдсан асуудлыг тухай бүр шийдвэрлэн, гүйцэтгэлийн хяналтыг сайжруулах.	Менежер Г.Дагвадорж, ТХҮХ
9	Үер усны аюулаас урьдчилан сэргийлэх чиглэлээр байгууллагууд ажлын уялдаагаа, хангаж, тулгамдсан асуудлыг тухай бүр шийдвэрлэн ажиллах.	ОБХ, Холбогдох байгууллагууд
ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР		
10	Дүүргийн хэмжээнд хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагааг эрчимжүүлж ажиллах.	ХААА
11	ЕБС, СӨББ-ууд 2024-2025 оны хичээлийн шинэ жилийн бэлтгэлийг хангах. (сургуулийг 2 хуваах асуудал, цайны газар, элсэлт г.м)	Боловсролын хэлтэс, ЕБС, СӨББ-ууд
12	Дүүрэг орон нутгийн хэмжээний мэдээ мэдээллийг иргэд, олон нийтэд нэгдсэн байдлаар хүргэх ажлыг шуурхай зохион байгуулах.	ТЗУХ